| ХХус төсөв | 299 | 206 | 191 | 227 | 238 | 135 | 91 | 112 | 203 | 217 | 216 | 193 | 2329 |
| ХХус ААН | 207 | 234 | 290 | 220 | 300 | 244 | 155 | 155 | 299 | 227 | 331 | 298 | 2960 |
| ХХус /м³/ | 9931 | 9850 | 9184 | 9649 | 8810 | 8040 | 7959 | 7942 | 8479 | 8190 | 9330 | 7225 | 104589 |
| ХХУс /хүн тоо/ | 600 | 586 | 585 | 581 | 560 | 562 | 562 | 540 | 522 | 511 | 500 | 497 | 6606 |
| Уурхай дулаан / ГЖ / | 11851 | 13347 | 9917 | 8904 | 3376 | 371 | 413 | 451 | 1319 | 3588 | 9520 | 13197 | 76254 |
| Халаалт төсөв /төг/ГЖ | 427594005 | 439067125 | 309120461 | 206744639 | 95241485 | 25200449 | 26109055 | 22201456 | 52895110 | 112480053 | 235978882 | 277778015 | 2230410735 |
| Халаалт ААН төг/ГЖ | 387450051 | 387698237 | 284698096 | 177066051 | 77371567 | 3493749 | 1426020 | 3137244 | 7819343 | 54476341 | 155888500 | 203350452 | 1743875651 |
| Халаалт төсөв /төг/м³ | 4442377 | 5533648 | 5533648 | 5533648 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 5640529 | 5640518 | 5639909 | 37964275 |
| Халаалт ААН /төг/м³/ | 66613648 | 62732054 | 63383360 | 57847206 | 13271211 | 855564 | 0 | 0 | 11964835 | 47632879 | 57464993 | 91981359 | 473747108 |
| Халаалт /төг/м²/ | 162985588 | 162938291 | 163041275 | 165232984 | 82512254 | 0 | 0 | 0 | 81599871 | 168086658 | 168258051 | 169980792 | 1324635764 |
| Халаалт айл /төг/ГЖ/ | | | | | | | | | | | 2692725 | 0 | 2692725 |
| ХХус төсөв | 8891311 | 6131413 | 5676791 | 6743044 | 7071245 | 4013006 | 2700201 | 3334226 | 6019509 | 6437145 | 6414876 | 5730749 | 69163517 |
| ХХус ААН | 4942277 | 5577542 | 6901852 | 5230123 | 7122759 | 5791347 | 3689706 | 3677842 | 7098878 | 5403267 | 7863122 | 7086844 | 70385560 |
| ХХус /төг/м³/ | 20745859 | 20576650 | 19185376 | 20156761 | 18404090 | 16795560 | 16626351 | 16590838 | 17712631 | 17108910 | 19490370 | 15093025 | 218486421 |
| ХХус хүн тоо | 2429400 | 2372714 | 2368665 | 2352469 | 2720760 | 3185416 | 3185416 | 3060720 | 2536137 | 2069039 | 2024500 | 2012353 | 30317589 |
| ША нийт | 37927145 | 37490086 | 26905764 | 16411390 | 6744853 | 1434710 | 1376754 | 1266935 | 3054001 | 8447522 | 20081946 | 24454699 | 185595806 |
| Суурь хураамж | 23975413 | 23982453 | 23957109 | 24445696 | 24355573 | 22705398 | 22705398 | 22727926 | 24340507 | 24659700 | 24737140 | 24821620 | 287413934 |
| Уурхай дулаан төг/ГЖ | 393856310 | 443575541 | 329582475 | 295907509 | 112189957 | 12321626 | 13734312 | 14997043 | 43827619 | 119243987 | 316396273 | 438589098 | 2534221748 |
| **ДҮН** | **1541853384** | **1597675753** | **1240354873** | **983671520** | **447005754** | **95796825** | **91553213** | **90994231** | **258868442** | **571686030** | **1022931896** | **1266518915** | **9208910834** |
| Багануур ус | 210790672 | 212301208 | 184622378 | 155291001 | 92554064 | 53687949 | 49268494 | 49517513 | 76873616 | 120521339 | 159141955 | 185559592 | 1550129780 |
| 45.0% | 96612391 | 95535543 | 83080070 | 69880950 | 41649329 | 24159577 | 22170822 | 22282881 | 34593127 | 54234602 | 71613880 | 83501816 | 699314990 |
| 8.50% | 5234018 | 5224993 | 4490885 | 4138896 | 2077919 | 0 | 0 | 0 | 1653875 | 3693640 | 4224234 | 4224234 | 34962695 |
| YАБО | 16617782 | 10148509 | | | | | | | | | 311700 | 10016886 | 37094877 |




| Сар | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төлөвлөгөө | 1415378317 | 1302876202 | 1030230228 | 873925240 | 365080165 | 95663554 | 72373022 | 87548080 | 257968652 | 717324990 | 1022784317 | 1265450216 | 8506602983 |
| Гүйцэтгэл | 1541853384 | 1597675753 | 1240354873 | 983671520 | 447005754 | 95796825 | 91553213 | 90994231 | 258868442 | 571686030 | 1022931888 | 1266518921 | 9208910834 |
| Гүйцэтгэл % | 108.9 | 122.6 | 120.4 | 112.6 | 122.4 | 100.1 | 126.5 | 103.9 | 100.3 | 79.7 | 100.0 | 100.1 | 108.3 |
| Зөрүү дүн | 126475067 | 294799551 | 210124645 | 109746280 | 81925589 | 133271 | 19180191 | 3446151 | 899790 | -145638960 | 147571 | 1068705 | 702307851 |

Нийт борлуулалтын орлогын 9208.9 сая төгрөгийн

- 2,534.2 сая төгрөг буюу 29% Багануур ХК
- 2,485.0 сая төгрөг буюу 26% - Төсвийн байгуулага
- 2,320.9 сая төгрөг буюу 25% - Үйлдвэр аж ахуй нэгж
- 1,868.8 сая төгрөг буюу 20% - Айл өрх байна




## 6.4 ХЭРЭГЛЭЭНИЙ БҮТЭЦ, ХЭРЭГЛЭГЧДИЙН ТООН ТАЛААР

2024 оны жилийн эцсийн байдлаар нийт хэрэглээний 63.3%-ийг айл өрх, 14.4%-ийг ҮААНБ, 11.5%-ийг төсвийн байгууллага, үлдсэн 9.8%-ийг "Багануур" ХК-ийн хэрэглэгчид эзлэж байна.








“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг

## ДОЛОО. ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Мөрдөж ажиллах шаардлагын үзүүлэлт 4. Дулаан үйлдвэрлэх тоноглолын засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй бүрэн хийж гүйцэтгэх, үр ашиг өгөөжийг тооцож тайлагнах.
Биелэлт: ТЗБАХ, Их засвар, Хөрөнгө оруулалтын ажлын талаар.

а/. 2024 оны, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх Хөрөнгө оруулалт, Их засвар, ТЗБАХ-ний хүрээний ажлыг түрүү оны сүүлийн улиралд “”БНДС” ТӨХК-ийн Үйлдвэрлэлд барих ТЕХНИКИЙН ҮНДСЭН БОДЛОГО”, ТЕХНИКИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ӨНГӨРСӨН ХАЛААЛТЫН УЛИРАЛД ГАРСАН ГЭМТЭЛ СААТЛЫН СУДАЛГАА зэрэг гол гол бичиг баримтуудад уялдуулан төлөвлөсөн боловч станцын эдийн засгийн чадамжаас шалгаалан голлох, өртөг өндөртэй техникийн чанартай ажлууд хойшлогдсон. Гэвч станцын санхүү төлбөрийн чадварын боломжинд тулгуурлан, өндөр биш өртөг зардал бүхий тодорхой хэмжээний ажлуудыг сонгон, төлөвлөж, баталгаажуулсан. Үүнд ТЗБАХ-ний хүрээний 3 нэр төрлийн ажлыг 197,0 сая төгрөгөөр, Хөрөнгө оруулалтын 22 нэр төрлийн ажлыг 496,8 сая төгрөгөөр, Их засварт 5 нэр төрлийн ажлыг 289,0 сая төгрөгөөр , нийт 30 нэр төрлийн ажлыг 982,8 сая төгрөгийн зардлаар гүйцэтгэхээр төлөвлөж, нийт дээрх 30 нэр төрлийн ажлыг зохих тооцсон өртөгтэйгөөр нь бүрэн хэмжээнд гүйцэтгэсэн.
Нийт ажлуудыг гүйцэтгэхдээ “Төрийн болон орон нутгийн өмчийг худалдан авах тухай” хууль дүрмийн заалтыг хэрэгжүүлж ажилласнаас гадна ИЗ, ТЗБАХ, ХО-ын ажлуудыг техникийн эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй бүрэн хэмжээнд гүйцэтгэсэн.

б/ Төлөвлөгөөнд орж хэрэгжүүлсэн бүх ажлуудын хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийн талаар товч тайлбар хийв. Үүнд:

Ажлын нэр:
**“К-3 зуухны, фестоны халах гадаргуу солих, мөн зуухны конвективны халах гадаргуур бүрэн шинэчлэх.”ажлын техникийн шаардлага, ач холбогдол.”**

Төрөл: **ИХ ЗАСВАР**
Зарцуулсан хөрөнгө: **130 000 000 ₮**

НЭГ. **Ус халаалтын “КВТС-10-150” маркын К-3 зуухны өнөөгийн байдал, ША /шуурхай ажиллагаа/-ны түвшин.**
1.К-3 зуух бол тус Станцын халаалтын бус улиралд болон завсар(хавар, намрын) –ын бага ачаалалд зориулагдсан үндсэн тоноглол бөгөөд 2009 онд ашиглалтад орсон.>>>



**“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг

## ДОЛОО. ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

>>> 2. Дараагийн энэ зуухыг их засварт хамруулахаас аргагүй болсон нэг томоохон шалтгаан бол уг зуухны галын хотлын конвектив халах гадаргуугын, тасралтгүй он удаан жил ажилласны улмаас үүссэн ашиглалтын томоохон хэмжээний элэгдэл болох тухайн труба хоолойн нимгэрэлт цооролтын үед үүсдэг хүндрэл юм. Тухайн зуухны конвектив халах гадаргуугын багцын нийт 11 ш байхаас 60% нь заглушка хийгдсэн нь ША-ны үед зуухаар дамжин өнгөрөх сүлжээний усны зарцуулалт хязгаарлагдсаны улмаас хэвийн ажиллах нөхцөл алдагдсан байсан тохиолдол болно

ХОЁР. **Уг үндсэн тоноглолын үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн техник технологийн өөрчлөлт, шинэчлэлт**

1. Зуухны галын хотлын конвектив халах гадаргуугын 11ш багц хоолойг бүрэн шинэчилж, угсаралтын ажлыг хийсэн.
2. Зуухны фестоны халах гадаргуун нэг бүрчлэн шинэчлэв.
3. Зуухны фестоны халах гадаргуу болон конвектив халах гадаргуугын дээд доод, Ф219х11мм-ийн коллекторуудыг нэг бүрчлэн авч бүрэн үзлэг, цэвэрлэгээ хийсэн.
4. Конвектив халах гадаргуугын хэсгийн дулааны изоляци, обмуровкын хэсгийг шинээр бүрэн хэмжээнд хийж гүйцэтгэсэн.

ГУРАВ. **Уг зуухан төхөөрөмжид дээрх техник технологийн өөрчлөлт нэвтрүүлснээр гарсан техникийн болон эдийн засгийн ач холбогдол**

**<u>а/ Техник технологийн ач холбогдол:</u>**

1.Тус К-3 зуухны галын хотлын конвектив халах гадаргуу болон фестоны халах гадаргууд, дээр заагдсан их засварын ажил гүйцэтгэсээр, ДЭХ-ний үйлдвэрлэлт 3-4 Гкал/ц-аар нэмэгдсэн нь шинэчлэлт өөрчлөлтийн дараах туршилт тохируулгын ажиллагааны үед бүрэн батлагдсан.

2. Зуухны фестоны халах гадаргуу болон конвектив халах гадаргуугын дээд доод, Ф219х11мм-ийн коллекторуудыг нэг бүрчлэн авч бүрэн үзлэг, цэвэрлэгээ хийснээр уг зуухны найдвартай ажиллагааг хангасан.

3. Конвектив халах гадаргуугын хэсгийн дулааны изоляци, обмуровкын хэсгийг шинээр бүрэн хэмжээнд хийж гүйцэтгэснээр “орчинд алдагдах ДЭХ-ний алдагдлыг бууруулсан.

**<u>б/. Эдийн засгийн ач холбогдол:</u>**

1. К-3 зууханд дээрх их засварын ажлыг норм нормативын дагуу гүйцэтгэсний үр дүнд, өнгөрсөн хугацаанд 3112 цаг ажиллаж(энэ хугацаанд уг зуухны нүүрсний болон ЦЭХ-ний зарцуулалт зэрэг бусад өртгийн зарцуулалт, их засварт орохоос өмнөх үеийнхтэй адил байх нөхцөлд) >>>



**“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг

## ДОЛОО. ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

>>> 12448 Гкал ДЭХ-ийг нэмж үйлдвэрлэж, хамгийн багадаа **645 655, 4 мян.төгрөгний** ашгийг Станцад оруулсан гэж үзэж байна. Үүнд:

Товч тооцооллыг оруулвал:

$Q_1 * P_{ж} = Q_{ж}$ (Гкал/ж) , $Q_{ж}$ = **12448** Гкал/ж ; $Q_{ж} * R_{д.ө.} = G_{аш}$. (Мян.₮) , $G_{аш}$ = **1 076 092, 256** Мян.₮ ;

$G_{бол/аш} = G_{аш} * 60\%$ ; $G_{бол/аш}$ = **1 076 092, 256 = 60% = 645 655,4 Мян.₮** ;

$Q_1$ – **4 Гкал/ц.** Энэ нь их засварын дараах К-3 зуухны, хуучин ачаалал дээрээ нэмж гаргаж буй ДЭХ. /К-3 зуухны 2023 оны их засварын дараах, уг зуухны туршилт тохируулгын үеийн ажиллагаанаас./

$P_{ж}$ - **3112 цаг.** Их засварын дараах К-3 зуухны жилд ажилласан цаг. /Үүнийг Станцын К-3 зуухны, өнгөрсөн хугацааны ША-нд ажилласан цагийн дундажаар тооцож авсан./

$R_{д.ө}$ – **86447₮.** Нэгж ДЭХ-ний өртөг. /2024.12-р сарынх.Санхүү. Эдийн засагчаас/

$G_{аш}$ **–** (Мян.₮.). Жилийн нийт ашиг.

$G_{бол/аш}$ **–** (Мян.₮.). Жилийн нийт цэвэр ашиг. Үүнийг, дээрх тооцооны аливаа алдагдлыг бүрэн шингээх утгаар “$G_{аш}$ **–** (Мян.₮.). Жилийн нийт ашиг” - ийн 40%-ийг хасаж, цэвэр ашгийг 60%-иар тооцсон.

2. К-3 зуух буюу ”КВТС-10-150” маркын зуухан төхөөрөмжийн ША-ны үед гадна орчинд хаягдах Дулааны алдагдлыг, уг зуухны горим тогтооход 1,05% буюу 0,105 Гкал/ц гэж норомчилсон боловч бодит байдал 0,4-0,7 Гкал/ц гарсан байдаг. Уг их засварын ажлын дараагаар шинэчилсэн горим тогтоох үед хэмжилтээр (**$Q^{г.о}$-гадаад орчинд алдагдах дулаан(Гкал/ц)**)-нь 0,2 Гкал/ц-аар тоцогдсон нь их засварын ажлын үр дүнд дулааны изоляци, обмуровкыг шинээр сольж найдваржуулснаар 0,02-0,05% буюу 0,2-0,5 Гкал/ц орчим ДЭХ-ийг гадна орчинд хаягдахаас сэргийлж хэмнэсэн үүндээс нийт, хамгийн багадаа **58.2566-145.641,6 сая** төгрөгийн хэмнэлт гарсан. Үүнд:

Товч тооцооллыг оруулвал:

$Q^{г.о} * P_{ж} * R_{з.м.өр} = G_{аш}$ (Мян.₮.), $G_{аш}$ **= 97094,4 – 242736,0** (Мян.₮.) ; $G_{бол/аш} = G_{аш} * 60\%$ = **58256,6-145641,6** (Мян.₮);

$Q^{г.о}$ **– 0,2-0,5 Гкал/ц.** Их засварын үрд гадна орчинд алдах ДЭХ-ний хэмнэлт.

$P_{ж}$ - **3112 цаг.** Их засварын дараах К-3 зуухны жилд ажилласан цаг. /Үүнийг Станцын К-3 зуухны, өнгөрсөн хугацааны ША-нд ажилласан цагийн дундажаар тооцож авсан./

$R_{з.м.өр}$ **– 156,0** (Мян.₮.). 1 Гкал ДЭХ-ний өөрийн өртөг.

$G_{аш}$ **–** (Мян.₮.). Жилийн нийт ашиг.

$G_{бол/аш}$ **–** (Мян.₮.). Жилийн нийт цэвэр ашиг. Үүнийг, дээрх тооцооны аливаа алдагдлыг бүрэн шингээх утгаар “$G_{аш}$ **–** (Мян.₮.). Жилийн нийт ашиг” - ийн 40%-ийг хасаж, цэвэр ашгийг 60%-иар тооцсон.



**“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

## ДОЛОО. ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

>>> Ажлын нэр:
**“Химийн, Na-ийн анхан шатний 2 фильтер, тэдгээрийн шугам хоолой,хаалт арматурыг сэргээн засварлах.”ажлын техникийн шаардлага, ач холбогдол.”**

Төрөл: **ИХ ЗАСВАР**
Зарцуулсан хөрөнгө: **36 000 000 ₮**

НЭГ. **Станцын хими ус бэлтгэлийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, ША /шуурхай ажиллагаа/-ны түвшин.**

Тус станцын Хими ус боловсруулах хэсэг нь анхны проектоороо бүрэн гар ажиллагаа бүхий “Na-I” шатны 4, “Na-II” шатны 4, нийт 8 ус зөөлөрүүлэх фильтрийн системтэй ашиглалтанд орж, ША-нд тасралтгүй оролцож ирсэн бөгөөд улмаар 2013 оноос хуучин фильтрийн системүүд бүрэн хэмжээнд ашиглалтын элэгдэлд орж актлагдан, системд технологи шинэчлэлтэд хамрагдан үе шаттайгаар бүрэн автомат ажиллагаа бүхий, иж бүрэн 4 фильтрийн системийг ашиглаж эхлэсэн. Өнгөрсөн хугацаанд ус боловсруулах шинэ систем тасралтгүй ажиллаж ирсэн боловч зарим үед программын горим алдагдаж байсан зөрчил хэд хэд гарсан. Энэ нь сүүлийн үеийн Филь№1, Филь-№2 “FLECK-2900S“, Филь№3, Филь-№4 “F77A3“ тус тус маркын фильтрүүдийн электрон толгойн схемд платны гэмтэл гарах элбэг болсонтой холбоотой. Одоогоор, төвлөрсөн дулаан хангамжийн эзлэхүүн өсснөөр сүлжээний нэмэлт усны зарцуулалт ихэссэнтэй холбогдон ША-нд ажиллаж буй хими ус боловсруулах хэсгийн автомат ажиллагаа бүхий фильтрүүд нь найвдартай тасралтгүй ажиллагааг бүрэн хангаж чадахгүй чадлын дутагдалд орж байгаа асуудлыг өөрийн дотоод нөөц бололцоог ашиглан хямд зардлаар шийдвэрлэх техникийн зөвлөлийн шийдвэр гарсан. Иймээс бид Хими ус боловсруулах хэсгийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангахын тулд хуучин актлагдсан “Na-I”, “Na-II” шатны фильтрүүдээс 2ш -ийг хямд зардлаар “их засвар”-т хамруулж, бэлтгэл ажиллагаанд оруулсан болно.

ХОЁР. **Уг ажлыг гүйцэтгэснээр гарсан техникийн ач холбогдол:**

- Станцын Хими ус боловсруулах хэсэгт тулгамдсан, тухайн техник технологид үүссэн зөрчлийг оновчтой шийдсэн.
- Дотоод нөөц бололцоог бүрэн дүүрэн ашигласан.
- Засварын ажлыг маш түргэн шуурхай зохион байгуулж чадсан.
- Станцын ША-г тасралтгүй найдвартай явуулах нөхцөл бүрдсэн

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг



“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг

## ДОЛОО. ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

>>> ГУРАВ. Уг ажлыг гүйцэтгэснээр гарсан эдийн засгийн ач холбогдол:

- Дээрх, техникийн оновчтой шийдэлтэй холбогдон асуудлыг эдийн засгийн талд хэмнэлттэй шийдвэрлэгдсэн. Шинээр бүрэн хэмжээнд уг фильтрүүдийг зах зээлээс авч суурилуулж ашиглалтанд оруулахад 360 сая төгрөгийн өртөгтөй болно.
- Бусад эдийн засагтай хобогдох зарим нэг товч тооцооллолыг дор хураангүй байдлаар оруулав.

1. Хэрэв бидний Хими ус бэлтгэх хэсгийн технологи саатаж, 72 цагийн туршид сүлжээний схемийг “түүхий усаар” тэжээх нөхцөлд ямар хүндрэл, хор уршиг станцын ША-нд учирч болох талаар онолын товчхон тооцоо хийж үзье. Энэ тохиолдолд Станцын болон төвлөрсөн дулаан хангамжийн системд хоёр төрлийн томоохон технологийн чанартай зөрчил үүснэ. Үүнд:
   а/. Эх үүсвэр дээр, үндсэн тоноглол болох зуухан төхөөрөмжүүдийн ША-ны үеийн өндөр ачааллын үед “түүхий усаар” тэжээвэл, зуухны халах гадаргуу маш хурдан бохирдол зэвэрэлтэд өртөнө. Манай техникийн түүхий усны хатуулаг дундажаар 5160 мкг-экв/кг байдаг бөгөөд түүнийг бид “Хими ус бэлтгэх хэсгийн технологийн хэвийн ажиллагаа”-ны үр дүнд 40-50 мг-экв/кг болтол бууруулж сүлжээний нэмэлт усанд хэрэглэж ирсэн. Хэрэв Станцын ША-ны үед, зуухан төхөөрөмжүүдийн хамгийн их ачааллын нөхцөлд тэдгээрийг техникийн түүхий усаар буюу 5160 мкг-экв/кг хатуулагтай усаар 72 цагийн турш тэжээсэн гэж үзвэл, зуухны халах гадаргуун дотор хананд 0,27 мм зузаан зэврэлт (галын хотлын температурыг 1200 $^0C$, сүлж/усны зарцуулалтыг 247т/ц, хэмийг 115 $^0C$-ээр тус тус тооцсон) тогтоно. “Халах гадаргууд 1мм зузаан хаг тогтоход түлшний зарцуулалт 10% нэмэгддэг ба хагийн дулаан дамжуулах чадвар нь ердийн гангийнхаас ойролцоогоор 40 дахин бага байдаг. . .” гэсэн “алтан дүрэм” гэмээр ойлголтыг энд авч үзвэл:
   $B_{б.н} = B_{з.н} * V_{з.н}$ (т/ж.) ; $B_{б.н} = 1776,0$ тн/ж ; $G_{аш} = B_{б.н} * R_{з.м.өр} = 101,231$ (сая.₮.) ;
   $G_{бол/аш} = G_{аш} * 60\% = 60739.200$ (Мян.₮);



**"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг

## ДОЛОО. ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

>>> **$B_{б.н}$ – т/ж.** Түүхий усаар тэжээсэн үеийн нүүрсний зарцуулалт. .
**$B_{з.н}$ - 12,9 т/цаг-** энд 2022 оны нүүрс зарцуулалтыг бодитоор авч тооцов. Химийн боловсруулсан усаар тэжээх үед нэг зуухны цагийн нүүрсний дундаж зарцуулалт. ША-нд бүтэн жил буюу халаалтын улирлын цагийг 5087цаг гэж тооцвол **65,778 мян.тн** болно.
**$V_{з.н}$ – 0,27мм зэвэрэлтэд ноогдох түлш - 1776,0** (тн.). "1 мм зэврэхэд 10% буюу 6577,8 тн нүүрс илүү зарцуулах бол 0,27 мм-д хэд зарцуулах бэ" гэсэн байдлаар тооцсон.
**$R_{з.м.өр}$ – 57000(Мян.₮.).** 1 тн нүүрсний өртөг.
**$G_{аш}$ –** (Мян.₮.). Жилийн нийт ашиг.
**$G_{бол/аш}$ –** (Мян.₮.). Жилийн нийт цэвэр ашиг. Үүнийг, дээрх тооцооны аливаа алдагдлыг бүрэн шингээх утгаар "**$G_{аш}$ –** (Мян.₮.). Жилийн нийт ашиг" - ийн 40%-ийг хасаж, цэвэр ашгийг 60%-иар тооцсон.

Энд бид, Станцын ША-ны үед сүлжээнд нийлүүлэх нэмэлт усыг химийн боловсруулалт хийгүйгээр, өөрөөр хэлбэл түүхий усаар 72 цаг тэжээсэн үед үндсэн тоноглолын халах гадаргууд үүсэх 0,27мм зэврэлт хаг хусам тогтсон үед тухайн халаалтын улирлын хугацаанд гаргах түлшний хэтрэлт хэмнэлтийн тухайд үзэв. Үүнээс гадна зуухны халах гадаргуугийн ашиглалтын хугацаа тодорхой хэмжээнд буурна.

б/. Төвлөрсөн дулаан хангамжийн системийг бид 72 цаг түүхий усаар тэжээсэн нөхцөлд дулаан дамжуулах шугам хоолой (хамааралгүй схемийн нөхцөлд)-д 0,09-0,19мм хүртэл зэврэлт үүсэж, ажлын биеийн хурд буурсан хэсгийн шугам хоолой арматурын хөндлөн огтлолын доод хэсэгт хатуу ширхэглэг хэсэг, хаг хусам шаварлаг өтгөн байдлаар тунаж тогтох, улмаар бөглөрөх нөхцөл үүсэх эхлэл болдог. Орон нутгийн гадна агаараас хамааруулан халаалтын системийн сүлжээний усны хэмийг бодит нөхцөлд, дундачаар 70-100 0С-д барьдаг бөгөөд, энэ температурын утга нь ажлын бие болох ус, металл гадаргуутай харьцах явцад хамгийн их идвэхитэй урвалд орж зэврэх нөхцөл бүрддэг билээ.

Ажлын нэр:
**"К-6 салхилуур хөдөлгүүрт давтамж хувьсгуур суурилуулах (Иневертер ABB, 160 кВт)." ажлын техникийн шаардлага, ач холбогдол."**

Төрөл: **ИХ ЗАСВАР**
Зарцуулсан хөрөнгө: **36 000 000 ₮**

НЭГ. **К-6 зуухны салхилуурын салхилуурийн цахилгаан хөдөлгүүрийн ашиглалтын өнөөгийн байдал, ША /шуурхай ажиллагаа/-ны түвшин.**
Уг зуухны туслах тоноглол болох, томоохон эргэх механизм(салхилуур)-ын 160 квт-ын, 940 эрг/мин бүхий цахилгаан хөдөлгүүр нь 2003 онд суурилагдсан, ажиллагааны хувьд сайн.



**“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг

## ДОЛОО. ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

>>> Тухайн үеэс хойш давтамж хувьсгуургүй байгаа нь ихээхэн эрсдэл дагуулж байгаа болно. Үндсэн тоноглолын, ялангуяа томоохон цахилгаан хөдөлгүүрийн хувьд, техникийн шаардлага үзүүлэлтийн тал дээр түүнд тохирсон давтамж хувьсгуурь суурилуулж өгснөөр найдвартай ажиллагаа бүрэн хангагддаг.

ХОЁР. **Уг ажлыг гүйцэтгэснээр гарсан техникийн ач холбогдол:**

- Уг К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрт давтамж хувьсгуурь суурилуулж өгснөөр, тухайн тоноглолыг ажилд залгахад, эргэлтийн момент “0”-ээс эхлэж аажмаар хурдсах тул цахилгаан хөдөлгүүр өөртөө болон эргэх механизмийн бусад хэсэг эд ангийг эвдрэл гэмтэлт бага өртүүлнэ.
- Ашиглалтын үед тоноглолын тохируулга, үндсэн параметр тохируулах боломжоор хангана.
- Хөдөлгүүрийн эргэлттэй шууд холбоотой тул ажиллагааны үед тоноглолын тохируулгыг алсын зайнаас, маш нарийвлалтай өргөн хүрээнд найдвартай хийх бололцоог олгодог.
- Цахилгаан хөдөлгүүрийн ашиглалтын хугацааг уртасгаж өгнө.
- Үндсэн тоноглолын ашиглалт тодорхой хэмжээнд сайжирсан.

ГУРАВ. **Уг ажлыг гүйцэтгэснээр гарсан эдийн засгийн ач холбогдол:**

- К-6 зуух нь 2023 оны зун техник технологи шинэчлэлтийн арга хэмжээнд хамрагдаж амжилттай, үр дүнтэй шинэчлэлт болсон тул их ачаалалын үед тасралтгүй ажиллах гол үндсэнсэн тоноглол болсноос, тэрхүү тоноглолын ЦЭХ-ний хэрэглээг хэмнэлттэй горимд шилжүүлэх нь эдийн засгийн хувьд ач холбогдол өндөртөй юм.
- 160 квт-ын, 940 эрг/мин бүхий цахилгаан хөдөлгүүрт түүнд тохирсон давтамж хувьсгуурь суурилуулж өгснөөр ЦЭХ зарцуулалтыг, хамгийн багадаа 15-30% хэмнэх боломжтой болдог.
- Уг цахилгаан хөдөлгүүрийн ЦЭХ зарцуулалтын хэмнэлтийн талаар товч тооцоолол оруулав. Цахилгаан хөдөлгүүрт түүнд тохирсон давтамж хувьсгуурь суурилуулж өгснөөр ЦЭХ зарцуулалтыг хэр хэмжээнд хэмнэснийг тухайн хөдөлгүүрт давтамж хувьсгуурь суурилуулаагүй байх үеийн үзүүлэлтийг, суурилуулсны дараах мөн үеийн үзүүлэлттэй харьцуулсан байдлаар гаргав. Үүнд:

**$W^{\text{х.о}} * T^{\text{х.о}} * V^{\text{тар}} = G^{\text{хо1}}$; $G^{\text{хо1}} = 19293.1$; $G^{\text{хо2}} = 21608.3$; $G^{\text{хо3}} = 27560.3$; $\sum G^{\text{хо}} = 68461.7$** (мян.₮);
**$W^{\text{ш.о}} * T^{\text{ш.о}} * V^{\text{тар}} = G^{\text{шо1}}$; $G^{\text{шо1}} = 14982.1$; $G^{\text{шо2}} = 17137.6$; $G^{\text{шо3}} = 22140.6$; $\sum G^{\text{шо}} = 54260.3$** (мян.₮); **$\Delta\sum G^{\text{х.ш.о}} = 14201{,}4$** (мян.₮);



**“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**


PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг


## ДОЛОО. ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

>>> $\Delta\sum G^{х.ш.о}$**= 14201,4** (мян.₮);

**$W^{х.о}$ –** Хуучин оны буюу 2023 оны 1, 2, 3 дугаар сарын, К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрийн ЦЭХ-ний цагийн зарцуулалт (кВт/ц ); (**$W^{хо1}$= 145; $W^{хо2}$= 139,2; $W^{хо3}$= 143,4** кВт/ц).

**$T^{х.о}$** – Хуучин оны буюу 2023 оны 1, 2, 3 дугаар сарын, К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрийн ажилласан цаг (ц). (**$T^{хо1}$= 432; $T^{хо2}$= 504; $T^{хо3}$= 624** ц).

**$V^{тар}$ –** Нэгж ЦЭХ-ний дундаж өртөг/тариф/ (₮); (**308** ₮)

**$G^{хо1}$; $G^{хо2}$; $G^{хо3}$; –** Хуучин оны буюу 2023 оны 1, 2, 3 дугаар саруудын тус бүрийн, К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрийн ЦЭХ-ний зардал (мян.₮).

**$\sum G^{хо}$ –** Хуучин оны буюу 2023 оны эхний улирлын, К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрийн ЦЭХ-ний зардал (мян.₮).

**$W^{ш.о}$ –** Шинэ оны буюу (давтамж хувьсгуур суурилны дараах он) 2024 оны 1, 2, 3 дугаар сарын, К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрийн ЦЭХ-ний цагийн зарцуулалт (кВт/ц ); (**$W^{шо1}$= 113,6; $W^{шо2}$= 110,4; $W^{шо3}$= 115,2** кВт/ц);

**$T^{ш.о}$** – Шинэ оны буюу (давтамж хувьсгуур суурилны дараах он) 2024 оны 1, 2, 3 дугаар сарын, К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрийн ажилласан цаг (ц) ; (**$T^{шо1}$= 432; $T^{шо2}$= 504; $T^{шо3}$= 624** ц).

**$V^{тар}$ –** Нэгж ЦЭХ-ний дундаж өртөг/тариф/ (₮); (**308** ₮)

**$G^{шо1}$; $G^{шо2}$; $G^{шо3}$; –** Шинэ оны буюу (давтамж хувьсгуур суурилны дараах он) 2024 оны 1, 2, 3 дугаар саруудын тус бүрийн, К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрийн ЦЭХ-ний зардал (мян.₮).

**$\sum G^{шо}$ –** Шинэ оны буюу (давтамж хувьсгуур суурилуулсны дараах он) 2024 оны эхний улирлын, К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрийн ЦЭХ-ний зардал (мян.₮).

**$\Delta\sum G^{х.ш.о}$ –** К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрт давтамж суурилуулсан болон суурилуулаагүй үеийн ЦЭХ зарцуулалтын зардлын зөрүү буюу хэмнэлт (мян.₮).

Тооцоонд, ЦЭХ-ний хэмнэлтийг зөв тооцохын тулд тухайн цахилгаан хөдөлгүүрт давтамж суурилуулсан болон суурилуулаагүй үеийн ажилласан цаг, ЦЭХ-ний дундаж өртөг зардлыг адил байхаар сонгосон болно.

## ДОЛОО. ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

>>> Иинхүү К-6 зуухны салхилуурын цахилгаан хөдөлгүүрт давтамж хувьсгуурь суурилуулж өгснөөр, түүний ашиглалтын хугацаа ихсэх, ашиглалтын үед тохируулга хийхэд хялбар байхаас гадна энэ арга хэмжээ авнаас хойш ганцхан улирлын хугацаанд **14201.4 мян.төгрөгийн ЦЭХ-ний хэмнэлт бодитоор гарсан** байгааг бид тогтоосон болно.

Ажлын нэр: **"БНДС" ТӨХК-ийн Эх үүсвэр, дулаан хангамжийн системд Эрчим хүчний бүрэн хэмжээний, техникийн аудит гүйцэтгэх." ажлын техникийн шаардлага, ач холбогдол."**

Төрөл: **ТЗБАХ**

Зарцуулсан хөрөнгө: **80 000 000 ₮**

НЭГ. **Тус станцын үндсэн үйлдвэрлэл, төвлөрсөн дулаан хангамжийн системийн үйл ажиллагаанд ЭХ-ний техникийн аудит хийх шаардлага, түүний гүйцэтгэл.**

Холбогдох хууль дүрэм, үйлдвэрлэлийн техник технологийн шаардлагаас хамааруулан бид энэ удаад, тусгай зөвшөөрөл бүхий ЭХ-ний техникийн аудитын мэргэжлийн багтай хамтран ажилласан нь өнөөдөр удирдан явуулж буй үйлдвэрлэлийн ША-ны түвшин, цаашид төсөөлж, төлөвлөж буй техник технологийн бодлогоо тодруулж дүгнэхэд ихээхэн ач холбогдол өгсөн.

НЭГ. **Урт хугацааны төлөвлөлт, зураглал:**

1. Тус Дулааны станцын эх үүсвэр болох үндсэн үйлдвэрлэл, дүүргийн төвлөрсөн дулаан хангамжийн системийг бүрэн хамруулан, техник технологийн бүхий л системд мэргэжлийн техникийн аудит гүйцэтгэж, захиалагч болох "БНДС" ТӨХК-ийн талд танилцуулсан. Станцынхан үүнд үндэслэн цаашдын ажлаа төлөвлөж эхлээд байна.
2. Багануурын Дулааны станцын техник технологийн өнөөгийн түвшинг үнэлж, технологийн үйл ажиллагааг хянаж, техникийн зөрчил түүний шалтгаануудыг технологийн дамжлага, хэсэг нэгж бүр дээр тодруулж тайланг бичгээр үлдээсэн. Энэ тайлангийн дагуу үнэлгээ эрэмбэлэлт хийгдэж байна.
3. Аудитын багийн зүгээс техник технологийн ажиллагааг сайжруулах, эдийн засгийн алдагдлыг бууруулах санал, шийдлүүдийн томоохон арга хэмжээнүүдийг оруулж ирсэнтэй бид хэсэгчлэн танилцаж байна.
4. Үйлдвэрлэлийн ША-нд болон хөрөнгө оруулалтаар хамгийн эхний ээлжинд гүйцэтгэх ажил үйлчилгээг Аудитын тайланд тусгасныг тодруулахаар ажиллаж байна.
5. Мөн Эдийн засгийн алдагдалын нөлөөллийг тодорхойлж, эрэмбэлэх, үнэлэх ажлууд эхлээд байна.



"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг



**“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг

## ДОЛОО. ИХ ЗАСВАР, ТЗБАХ-НИЙ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

>>> ХОЁР: **Ойрын болон дунд хугацааны төлөвлөлт, ажлын чиглэл:**

1. Үйлдвэрийн үндсэн түүхий эдийн ашиглалтанд бодит судалгаа хийж гарсан дүгнэлтүүд дээр ажиллах.
2. Үндсэн тоноглолын үйл ажиллагаа, тэдгээрийн технологид өөрчлөлт шинэчлэлт оруулснаар хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжийн талаар гаргасан зөвөлгөө, шийдлүүд дээр ажиллах.
3. Орлогын шинэ эх үүсвэр гаргах, зарлагыг бууруулах тал дээр гаргасан бодит шийдлүүд дээр ажиллах.
4. Ойрын жилүүдэд хэрэгжүүлэх техникийн бодлогын төслийг Аудитын зөвлөмжид тулгуурлан боловсруулах ажлууд тус тус хийгдэж байна

**“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2024 ОНД ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХАМРАГДСАН АЖЛУУДЫГ ГҮЙЦЭТГЭХ БОЛСОН ТЕХНИКИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГА, ТУХАЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭСНЭЭР ГАРСАН ТЕХНИКИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН АЧ ХОЛБОГДОЛ.**

| д/д | Төлөвлөгдсөн ажлын жагсаалт | Зарцуулах хөрөнгө /сая.төг./ | Зайлшгүй хийгдэх болсон техникийн шаардлага | Уг ажлыг гүйцэтгэснээр гарсан үр дүн. | Техникийн болон эдийн засгийн ач холбогдол, |
|---|---|---|---|---|---|
| | **1. Хөрөнгө оруулалтын ажил.** | | | | |
| 1 | **Хими хэсэгт Фильтрийн толгой /FLEECK-2900 маягийн фильтр/** | 20,0 | Станцын хими хэсэгт, өнөөгийн байдлаар 4 иж бүрэн, автомат ажиллагаа бүхий “FLEECK-2900” маягийн ион солилцооны фильтр ША-нд ажиллаж байгаа бөгөөд тэдгээрийн үндсэн үйл ажил лагааг нь тэдгээр үндсэн тоног төхөөрөмжүүд ийн электрон толгойн тусгай програм хангамж гүйцэтгэдэг бөгөөд уг элктрон схем бүхий толгойн хэсэг гэмтсэн тохиолдолд бүрэн хэмжээнд шинээр солих шаардлагатай болдог, түүнийг гадаадаас захиалж авах хэрэг гардаг тул аваарийн бэлтгэлд бэлэн авсан байх шаардлагатай | Одоогоор ША-нд тасралт гүй явж буй фильтрүүд ийн аль нэг нь удирдлагын электрон схемийн гэмтлээр зогссон үед аваарийн бэлтгэлийг ашиглах бөгөөд, тэр хугацаанаас дараагийн аваарийн бэлтгэлийг гадаад руу захиалах болсон. Ингэснээр ША саадгүй явагдах ба аваарийн нөөц мөн бэлтгэгдсэн байхаар зүхион байгуулсан нь оновчтой болсон. | **<u>1.Техникийн ач холбогдол:</u>** -Техникийн технолог ийн жигд ажиллагаа хангагдсан. - ША-ны горим зөрчигдөхгүй байх боломжоор бүрэн хангагдсан. **<u>2.Эдийн засгийн ач холбогдол:</u>** - Энэхүү арга хэмжээ нь үйлдвэрлэлийн технологийн дагуух жигд ажиллагааг хангасан бөгөөд ингэснээр Дулааны энерги үйлдвэрлэх, түгээх бүх процессийн экраны систем, шугам хоолой хаалт арматурын бохирдол зэврэлт багасаж, ашиглалтын хугацаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | уртсах нөхцөл бүрдсэн юм. |
| 2 | **Давсны насос /марк тип/** | 10,0 | Их засварын хэсэгт Химийн, Na-ийн анхан шатний 2 филь тер, тэдгээрийн шугам хоо лой,хаалт арматурыг сэргээн засварлах ажил багтсан бө гөөд тэдгээр үндсэн тоног лолуудыг хэвийн ажиллуула хад “Давсны уусмал татах” хос жижиг насос зайлшгүй шаардагдах тул энэ ажлыг гүйцэтгэх болсон. | Давсны уусмал шахах жижиг оврын хос насосыг шинэчилснэ эр дээрх их засварт хамруулсан Na-ийн анхан шатний 2 филь терийн хэвийн ажиллагаа хангагдах бас нэгэн чухал нөхцөл бүрдсэн. | **<u>1.Техникийн ач хол богдол:</u>**<br>- ША-г сааталгүй го римын хэмжээнд яв уулах боломж бүрдсэн.<br>**<u>2.Эдийн засгийн ач холбогдол:</u>**<br>- Аливаа үйлдвэрлэлийн процесс өгөгдсөн технологийн дагуу явна гэдэг нь өөрөө эдийн засгийн томоо хон хэмнэлт болно. |
| 3 | **ДН-17-ийн ажлын дугуй/материал/** | 34,0 | Тус станцын үндсэн тоноглолын циклоны төхөөрөм жүүд бүгд ашиглалтын хугацаа бүрэн дуусаж, элэгдэлд орж ажиллагаагүй болсон. Бүрэн засварлахад хамгийн багадаа 2,2 тэрбум төгрөг шаардаг дана. Мөн үүний улмаас ДС(зуухны утаа сорогч)-ын ажлын дугуй ихээр элэгдэх болсон. Бид циклоны систем ийг | ДС-ын ажлын дугуй бэлэн байхад ША-ны ямар ч үед зуухны ажиллагааг саатуу лахгүй солих боломжтой болсон. | **<u>1.Техникийн ач хол богдол:</u>**<br>- Дотоод нөөц боломжоог ашиглан ША-г доголдолгүй явуулах арга хэмжээг авч байна.<br>**<u>2.Эдийн засгийн ач холбогдол:</u>**<br>- Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажилла гааг тасралтгүй явуулах нь алдаглыг нэмэг дүүлэхгүй байх нөхцөл |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | засаж сайжруулах хөрөн гөгүй тул ДС-ын ажлын дугуйг өөрсдөө хийж ойр ойрхон шинээр сольж, ША-гаа сааталгүй явуулж ирсэн. | | бүрдэж байгаа. |
| 4 | **СЭН-6 насос шинэчлэх /Д-320-70/** | 45,0 | Халаалтын бус улиралд, станцын эдийн засгийн алдаг далыг багасгах зорилгоор тухайн үеийн ачааллалд тохир сон үндсэн тоноглол үйлдвэр лэлд ашиглаж ирсний нэг нь сүлжээний насос болох СЭН-6 /Д-320-70/ . Уг насос нь 2001 онд ашиглалтанд орж, өнөөд рийн байдлаар ашиглалтын хугацаа дууссан, найдвартай ажиллагаа муудсан тул шинэч лэх шаардлагатай болсон. | СЭН-6 /Д-320-70/сүлжээни й насосыг шинэчилснэ эр ША-ны найдвартай тасралтгүй ажиллагаа сайжирсан. | **<u>1.Техникий н ач хол богдол:</u>**<br>- Техникийн тулгамдсан асуудал шийдэг дэж, ША хэвийн явагдах нөхцөл бүрдсэн.<br>**<u>2.Эдийн засгийн ач холбогдол:</u>**<br>- Үйлдвэрлэл ийн үндсэн үйл ажилла гааг тасралтгүй явуулах нь алдаглыг нэмэг дүүлэхгүй байх нөхцөл бүрдэж байгаа. |
| 5 | **Ду-150 Ру-16 /Угаах хаалт/** | 7,0 | Үнс зайлуулах системийн технологийн хаалт, 1997 онд тавигдсан, ашиглалтын хуга цаа бүрэн дууссан. Хаагдахгүй болсон, бүрэн шинэчлэх шаардлагатай. | ША –г хэвийн зөрчилгүй явуулах боломжоор хангагдсан. | **<u>1.Техникий н ач хол богдол:</u>**<br>- Техникийн тулгамдсан асуудал шийдэг дэж, ША хэвийн явагдах нөхцөл бүрдсэн. |
| 6 | **Ду-300 Ру-16 /ГЗУ-н түүхий усны өгөх хаалт/** | 10,0 | Станцыг техникийн түүхий усаар хангах | ША –г хэвийн зөрчилгүй | **<u>1.Техникий н ач хол богдол:</u>** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | системийн техно логийн хаалт, 1987 онд тавигдсан, ашиглалтын хуга цаа бүрэн дууссан. Хаагдахгүй болсон, бүрэн шинэчлэх шаар длагатай. | явуулж байна. | - Техникийн тулгамдсан асуудал шийдэг дэж, ША хэвийн явагдаж байгаа. |
| 7 | **Ду-200 Ру-25 /К-8 зуухны орох хаалт/** | 8,0 | Үндсэн тоноглолын орох хаалт, 1980 онд тавигдсан, ашиглалтын хугацаа бүрэн дууссан. Хаагдахгүй болсон, бүрэн шинэчлэх шаар длагатай. | ША –г хэвийн зөрчилгүй явуулж байна. | **1.Техникийн ач хол богдол:** - Техникийн тулгамд сан асуудал шийдэг дэж, ША хэвийн явагдана. |
| 8 | **Хими хэсэгт Фильтрийн ион солилционы материал** | 56,0 | Хими хэсгийн үйлдвэрлэлийн технологи ажиллагааг хэвийн явуулах шаардлагтай. | Станцын ША –г хэвийн зөрчилгүй явуулж байна. | **1.Техникийн ач хол богдол:** - Техникийн тулгамдсан асуудал шийдэг дэж, ША хэвийн явагдаж байгаа. **2.Эдийн засгийн ач холбогдол:** - Аливаа үйлдвэрлэлийн процесс өгөгдсөн технологийн дагуу явна гэдэг нь өөрөө эдийн засгийн томоохон хэмнэлт болно. |
| 9 | **Компьютер /СЭН удирдлага хүчдэл баригчтай/** | 8,0 | Үйлдвэрлэлийн автомат удирд лагын хэсгийг найдваржуулах, доголдлыг арилгах. | СЭН-ийн удирдлагын системийн найдвартай ажил лагаа хангагдсан. | **1.Техникийн ач хол богдол:** - Техникийн тулгамдсан асуудал шийдэг дэж, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | ША хэвийн явагдаж байгаа. |
| 10 | **ГЗУ-н насос /К-80-100/** | 20,0 | Станцыг техникийн түүхий усаар хангах системийн техно логийн тоноглол, 1989 онд тавигдсан, ашиглалтын хуга цаа бүрэн дууссан. Ажлын даралт гаргахгүй болсон, бүрэн шинэчлэх шаар длагатай. | ША –г хэвийн зөрчилгүй явуулж байна. | **1.Техникийн ач хол богдол:**<br>- Техникийн тулгамдсан асуудал шийдэг дэж, ША хэвийн явагдаж байгаа. |
| 11 | **Туузан дамжуулгын ремень-800** | 20,0 | Тус станц нь үйлдвэрлэлийн технологид нийт 760м урт туузан дамжлага ашиглаж ирсэн. Жилд 100м урт туузан дамжлагыг шинэчилхээр шийдвэр гарсан. | ША-г нүүрсээр тасралтгүй хангах ажиллагаа бүрэн найдваржсан. | **1.Техникийн ач хол богдол:**<br>- Техникийн тулгамд сан асуудал шийдэг дэж, ША хэвийн явагдаж байгаа.<br>**2.Эдийн засгийн ач холбогдол:**<br>- Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажилла гааг тасралтгүй явуулах нь алдаглыг нэмэг дүүлэхгүй байх нөхцөл бүрдэнэ. |
| 12 | **Нэмэлт халах гадаргуугийн труба /ф60х5 труба/** | 10,0 | Одоогоор ША-нд нийт 7 зуухны нийт 161 орчим нэмэлт халах гадаргуу дулаан солилцооны процест ажиллаж байна. Тех нологи | Үндсэн тоноглолын гэмт лийг цаг алдалгүй устгах. ША-ны горимын зөрчилгүй ажиллах нөхцөл бүрдсэн. | **1.Техникийн ач хол богдол:**<br>- Техникийн ашиглал тын үед байнга гардаг гэмтэл саатлыг хурдан устгах нь ША-ны |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагааны нөхцлийн хувьд нэмэлт халах гадаргуу нь галын хотлын буцламтгай хөдөлгөөн бүхий энертын материалын орчинд байр ладаг тул элэгдэлд амархан ордог. Үйлдвэрлэлийн нөх цөлд гэмтсэн нэмэлт халах гадаргууг тухайн үед нь солих, оруулга оруулах шаардлага байнга гардаг тул түүнд хэрэглэх Ф60х5мм-ийн шугам хоолойг байнга бэлэн байлгах шаардлагатай. | | өгөгдсөн горимыг зөрчилгүй барих үндэс болдог. **2.Эдийн засгийн ач холбогдол:** - Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг тасралтгүй явуулах нь алдаглыг нэмэг дүүлэхгүй байх нөхцөл бүрдсэн. |
| **13** | **К-6 зуухны ДВ-ын картер, гол бүхий ротор шинээр угсрах /ВДН-17/** | 48,0 | Уг зуухны салхилуур нь 1980 онд станцыг анх ашиглалтанд ороход суурилуулсан тэр хэв ээр ашиглагдаж ирсэн. Сүүлд зууханы хэсэгт технологийн шинэчлэлд ороход, хуучин тоноглолын үзүүлэлт гологдох болсон тул шинэчлэх шаардлага гарсан. | Нэг үндсэн тоноглол технологийн шаардлага хангаж ажиллах болсноор ША-ны найдвартай ажиллагаа нэмэгдсэн. | **1.Техникийн ач холбогдол:** - Техникийн тулгамдсан асуудал шийдэг дэж, ША хэвийн явагдаж байна. **2.Эдийн засгийн ач холбогдол:** -Үүнийг дагаад ашигт ажиллагаа нэмэгдсэн. |
| **14** | **Шуурхай ажиллагааны машин /toyota HAICE/** | 65,0 | Станцын ША-нд, ялангуяа өвлийн их ачааллын үед | ША-г саадгүй явуулах, ажиллагсды | **1.Техникийн ач холбогдол:** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | үйлчилгээний авто машин дутагдаж байгааг шийдвэрлэх. | н тав тухтай ажиллах нөхцөл хангагдсан. | - Техникийн саатлын үед цаг алдалгүй арга хэмжээ авах нөхцөл хангагдсан. **<u>2.Эдийн засгийн ач холбогдол:</u>** -Үүнийг дагаад ашигт ажиллагаа нэмэгдсэн. |
| **15** | **Мотор солих /PRIUS-30/** | 2,1 | Станцын өдөр тутамын үйлд вэрлэлийн ажиллагааг хянах, гадны харилцагч, хэрэглэг чидтэй холбогдох ажил арга хэмжээний чухал ганц унааны хэвийн ажиллагааг хангах | Станцын бүх хэсгүүдийн гадуурх ажиллагаан ы үйлчилгээ явуулах гол бололцоог хангах, Дулаан хангамжийн систем, хэрэглэгчтэй холбогдох аливаа ажил үйлчилгээг гүйцэлдүүлэх боломжийг хангасан. | **<u>1.Техникийн ач хол богдол:</u>** - Техникийн саатлын үед цаг алдалгүй арга хэмжээ авах нөхцөл хангагдана. **<u>2.Эдийн засгийн ач холбогдол:</u>** -Үүнийг дагаад ашигт ажиллагаа тодорхой хэмжээнд нэмэгдсэн. |
| **16** | **Зуухны утаа сорогч (хөдөлгүүр 160кВт 1000 об/мин)** | 25,0 | Аваарын нөөцийн заал тын дагуу хамгийн чухал нөөцийг бүрдүүлэх. | Үндсэн тоноглол энэ чиглэлийн техникийн зөрчлөөр саатахгүй байна. | **<u>1.Техникийн ач хол богдол:</u>** - Техникийн ашиглалтын үед байнга гардаг гэмтэл саатлыг хурдан устгах нь ША-ны өгөгдсөн горимыг зөрчилгүй барих үндэс болдог. **<u>2.Эдийн засгийн ач холбогдол:</u>** - Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажилла |
| **17** | **Зуухны цахилгаан редуктор (хөдөлгүүр 4кВт 1500 об/мин)** | 5,0 | Аваарын нөөцийн заалтын дагуу хамгийн чухал нөөцийг бүрдүүлэх. | Үндсэн тоноглол энэ чиглэлийн техникийн зөрчлөөр саатахгүй байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | гааг тасралтгүй явуулах нь алдаглыг нэмэг дүүлэхгүй байх нөхцөл бүрдсэн. |
| **18** | **Суурин компьютер i5 /4 ком/** | 12,0 | Ажлын байрны нөхцөл сайжруулах, ажил гүйцэтгэх шаард лагатай багаж хэрэгслээр хангагдах. | Ажлын байрны нөхцөл эрс сайжирсан. | |
| **19** | **Принтер /3 үйлдэлт/** | 2,2 | Ажлын байрны нөхцөл сайж руулах, ажил гүйцэтгэх шаард лагатай багаж хэрэгслээр хангагдах. | Ажлын байрны нөхцөл эрс сайжирсан. | |
| **20** | **Архивын сканнер** | 2,0 | Ажлын байрны нөхцөл сайж руулах, ажил гүйцэтгэх шаард лагатай багаж хэрэгслээр хангагдах. | Ажлын байрны нөхцөл эрс сайжирсан. | |
| **21** | **Дуу хураагуур,спикерийн хамт** | 2,620 | Холбогдох дүрэмд заасны дагуу Диспетчер инженерийн өрөөнд суурилуулах. | Үйлдвэрлэл ийн осол аваарийн үед холбогдох дүрэм журмын дагуу ажиллах нөхцлийг бүрдүүлсэн. | |
| **22** | **Ажиллагсдын ажлын үнэмлэх** | 0,705 | Байгууллагын дотоод журмын заалтыг хангах. | | |
| **23** | **Бичиг хэргийн шкаф** | 2,4 | Ажлын байрны нөхцөл сайжруулах, ажил гүйцэтгэх шаардлагатай багаж хэрэгслээр хангагдах. | Ажлын байрны нөхцөл эрс сайжирсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **24** | **Оффис тавилга/ширээ,сандал, шкаф/** | 8,0 | Ажлын байрны нөхцөл сайж руулах, ажил гүйцэтгэх шаардлагатай багаж хэрэгслээр хангагдах. | Ажлын байрны нөхцөл эрс сайжирсан. | |
| **25** | **Үйлдвэрийн зориулалт бүхий угаалгын машин** | 34,0 | Байгууллагын ажиллагсдын ажлын хувцасыг өөрсдийн хүчээр угааж цэвэрлэх. | Ажлын байрны нөхцөл эрс сайжирсан. | |
| **26** | **Оффис сандал** | 4,0 | Ажлын байрны нөхцөл сайж руулах, ажил гүйцэтгэх шаард лагатай багаж хэрэгслээр хангагдах. | Ажлын байрны нөхцөл эрс сайжирна. | |
| **27** | **Төвийн шугамтай холбодог ус шүүгч** | 1,450 | Ажлын байрны нөхцөл сайж руулах, ажил гүйцэтгэх шаард лагатай багаж хэрэгслээр хангагдах. | Ажлын байрны нөхцөл эрс сайжирсан. | |
| **28** | **Баримт үдэгч** | 0,450 | Ажлын байрны нөхцөл сайж руулах, ажил гүйцэтгэх шаард лагатай багаж хэрэгслээр хангагдах. | Ажлын байрны нөхцөл эрс сайжирсан. | |
| **29** | **Цайны газрын тохижилт /сандал, ширээ/** | 10,0 | Ажлын байрны нөхцөл сайж руулах, ажил гүйцэтгэх шаард лагатай багаж хэрэгслээр хангагдах. | Ажлын байрны нөхцөл эрс сайжирсан. | |
| **30** | **Диспетчер инженерийн өрөөнд дуу, дүрс бичлэгийн камер суурилуулах** | 0,5 | Холбогдох дүрэмд заасны дагуу Диспетчер инженерийн өрөөнд суурилуулах. | Үйлдвэрлэл ийн осол аваарийн үед холбогдох дүрэм журмын дагуу ажиллах | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | нөхцлийг бүрдүүлсэн. | |
| 31 | **Даацын тэрэг** | 6,0 | Үйлдвэрийн хэмжээнд ганц даацын тэрэг хэрэглэж ирсэн бөгөөд тухайн тэрэг нь 1990 онд ашиглалтанд орж, тасралтгүй хэрэглээний улмаас ажлын шаардлага хангахгүй болсон. | Ажлын байрны нөхцөл сайжруулах, ажил гүйцэтгэх шаард лагатай багаж хэрэгслээр хангагдсан. | **1.Эдийн засгийн ач холбогдол:** - Аваарь осолгүй, техникийн саатлагүй ажиллана гэдэг нь өөрөө Э/Засгийн том хэмнэлт юм. |
| **ДҮН** | | **587,615** | | | |

## НАЙМ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2024 онд өөрийн хөрөнгөөр техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалт, их засварын урсгал засварын хүрээнд нийт 2,150,602,218.69 (Хоёр тэр бум нэг зуун тавин сая зургаан зуун хоёр мянга хоёр зуун арван найм) төгрөгийн төсөвт өртөг бүхий 44 бараа, ажил, үйлчилгээ хийхээр төлөвлөсөн ба 2024-12-31-ны байдлаар нийт 2,015,980,368.69 /хоёр тэр бум арван таван сая есөн зуун наян мянга гурван зуун жаран найм/ төгрөгийн 42-н бараа, ажил, үйлчилгээг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу хийж гүйцэтгээд байна. 2024-12-31-ны байдлаар төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт гараагүй.

2024 онд хөрөнгө оруулалтын 15 , их засварын 4, техник зохион байгуулалтын арга хэмжээний 3, зардалд тооцсон худалдан авалтын 22, нийт 44 төрлийн бараа, ажил, үйлчилгээг 2,150,602,218.69 (Хоёр тэр бум нэг зуун тавин сая зургаан зуун хоёр мянга хоёр зуун арван найм) төгрөгт багтааж хийхээр төлөвлөсөн.
2024 оны жилийн эцсийн байдлаар дотоодын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс 64,325,500.00 төгрөгийн бараа материалыг " МТОТ" ХХК- аас худалдан авсан





“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ”ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг

## ЁС. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 278.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарахаар төлөвлөгөө батлагдсан боловч 595.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан.

## ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

- Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг шинэчлэх;
- Бүтэц орон тоог оновчтой зохион байгуулах;
- Ажилтан төвтэй ажлын байр” зорилт дэвшүүлж ажиллах

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

- Үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдол гаргалгүй ажиллах
- Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах

## САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГЛЭЛЭЭР

- 2024 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр хангаж ажиллах;
- Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллах;
- 2023 оны жилийн эцсийн тайлан тэнцлээр үүссэн өр авлагыг барагдуулж шинээр өр авлага үүсгэхгүй байхад анхаарч ажиллах.

## ДУЛААН ҮЙЛДВЭРЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

- Web технологи ашиглан цахилгаан тоног төхөөрөмж, техник технологитой холбоотой программ хангамжийг байнгын ашиглалтын горимд байлгах;
- Техникийн шинэчлэлтийн урт, дунд, богино хугацааны төлөвлөлтүүдийг ЭХЯ болон төрөөс ЭХ-ний талаар баримтлах бодлогын хүрээнд шинэчлэн боловсруулах, төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах болон хөрөнгө оруулалтыг татах;
- Компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа техникийн журмуудад өөрчлөлт хийж, дахин боловсруулах.

## ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- Хэрэглэгчдэд дулааны эрчим хүчний үнэ тариф, шинээр болон шинэчлэгдэн гарсан дүрэм журмыг сурталчилж хэрэглэгчийн уулзалтыг зохион байгуулах;
- Түгээлтийн алдагдлыг бууруулах талаар ажил зохион байгуулж ажиллах.

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- Тухайн жилийн худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийхгүй байх;
- Тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хууль дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэх



“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ”ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

PHONE:
70210132

WEBSITE:
https://web.bnds

EMAIL:
Info@baganuurdulaan.mn

Хаяг: Улаанбаатар хот
Багануур дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн хэсэг